



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/508

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн зөвлөхүүд, Эрчимжсэн мал ахуй болон сүүний фермийн төслийн удирдлагууд, Төв аймгийн нутгийн зөвлөл, Боловсрол, Шинжлэх Ухааны сайд болон холбогдох албаны зочид Төв аймагт ажиллах болсон тул шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зардалд шаардагдах 2,146,550 (хоёр сая нэг зуун дөчин зургаан мянга таван зуун тавь) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (С.Магнайбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР